



ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН ЯАМ  
СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ  
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2016 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А142

Улаанбаатар хот

Өндөржүүлсэн бэлэн байдал зарлах тухай

Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.1, Удирдлагын зөвлөлийн 2016 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Улсын хэмжээнд Улаанбурхан өвчний дэгдэлт хурдацтайгаар тархаж байгаа тул Яаралтай тусламжийн тасгийн тусгаарлах хэсгийн бэлэн байдалд хяналт тавьж, шаардлагатай нөөцөөр ханган ажиллахыг Эмчилгээ эрхэлсэн дэд захирал /О.Ганчулуун/, Яаралтай тусламжийн тасгийн эрхлэгчийн үүрэгт ажлыг түр орлон гүйцэтгэгч /Д.Дэжидмаа/ нарт үүрэг болгосугай.

2. Нийт клиникийн эрхлэгч, жижүүрийн эмч нар эмчлүүлэгчдэд бие махбодийн үзлэг сайтар хийж өвчний шинж тэмдэг илэрсэн болон өвчилсөн эмчлүүлэгчдийг нэн яаралтай тусгаарлах өрөөнд шилжүүлэн, халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.

3. Клиникийн тасгуудад тогтмол агаарын ариутгал хийж, өвчний талаар тандалт хийж, халдвар хамгаалал болон мэргэжил арга зүйгээр удирдан ажиллахыг Халдвар судлаач эмч /И.Байгальмаа/, бага эмч /Л.Мөнхгэрэл/ нарт үүрэг болгосугай.

4. Улаанбурхан өвчний талаар гарсан зөвлөмжийг нийт клиникийн эрхлэгч, ахлах сувилагч нарт тараан өгч, мэдээлэл хийж үйлчлүүлэгч ихээр төвлөрдөг поликлиник, удирдлагын байр, клиникүүд, сэргээн засах физик эмчилгээ, тасгууд, багуудын нийтэд ил тод харагдах газар байрлуулан өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг зохион байгуулан ажиллахыг Нийгмийн эрүүл мэнд, эрдэм шинжилгээ, сургалт, гадаад харилцаа, статистик, тандалт судалгаа эрхэлсэн дэд захирал /В.Баярмаа/-д үүрэг болгосугай.


5. Эмчлүүлэгчид, ажилтнуудын дархлааг дэмжиж чанартай хоол, хүнсний бүтээгдэхүүнээр үйлчлэхийг Ахлах тогооч /Б.Алтанцэцэг/, Сэтгэц нийгмийн сэргээн засах тасгийн эрхлэгч /Б.Алтанзул/, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэлээр

020286

хангаж ажиллахыг Сэтгэц нөлөөт эм зүйн тасгийн эм зүйч /Ё.Батсүх/-д тус тус үүрэг болгосугай.

6. Өндөржүүлсэн бэлэн байдлын үед холбогдох үүрэн холбооны утсаа салгахгүй байхыг Эмчилгээ эрхэлсэн дэд захирал О.Ганчулуун, Чанарын албаны дарга Н.Оюунчимэг, Сэтгэц нөлөөт эм зүйн тасгийн эм зүйч Ё.Батсүх, Халдвар судлаач эмч И.Байгальмаа, Яаралтай тусламжийн тасгийн эрхлэгчийн үүрэгт ажлыг түр орлон гүйцэтгэгч Д.Дэжидмаа, ахлах сувилагч Ц.Гэрэлмаа, жолооч Д.Баасанлхүндэв нар болон жижүүрийн эмч нарт үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Л.НАСАНЦЭНГЭЛ